

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

| ЗОРИГЖУУЛНА

| МЭДЭЛЖҮҮЛНЭ

Пүрэв, 2019.11.28, №9 (125)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.jargaldefacto.com

WEEKLY



ДеФакто **НИЙТЛЭЛ**

№506

Д.Жаргалсайхан

Эдийн засагч, нийтлэлч

Хараат бус болох ХАРГҮЙ ЗАМЫН ЭХЭНД

НИЙТЛЭЛ

НИЙГМИЙН ДААТГАЛ

V НҮҮРТ

ДеФакто **ТОЙМ**

➤ ОЮУТОЛГОЙН ГЭРЭЭГ
САЙЖРУУЛАХ УУ?

➤ НИЙГМИЙН ДААТГАЛ
ТОЙРСОН УЛС ТӨР

➤ МОНГОЛБАНК, САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ШИНЭ УДИРДЛАГУУД


VI НҮҮРТ

Хараат бус болох ХАРГҮЙ ЗАМЫН ЭХЭНД

Манай улс түлш, шатахуунаар Оросоос үеийн үед хамааралтай явж ирлээ. Улс орон хөгжихийн хэрээр улам олон унаа тэрэгтэй, тоног төхөөрөмжтэй болсоор эдүгээ бид 1.5 тэрбум доллар буюу валютын орлогынхоо дөрөвний нэгийг шатааж сууна. Оросуудын дуугарсан үнийг төлөхөөс өөр сонголтгүй байснаа, 2015 оноос Сингапурын зах зээлийн үнээр тохиролцсон нь бас ч үгүй баримжаатай болгов. Таван жилийн тохиролцоо дуусч, ирэх сард сунгахаар хэлэлцэх ажээ. Гол нь бид түлш шатахууныг доллараар аваад төгрөгөөр борлуулдаг учир ханшинд нөлөөлж, гадаад худалдааны тэнцлийг алдуулж, өргөн хэрэглээний барааны үнийг өсгөж, инфляцийг хөөрөгддөг.

Шатахуунаар хараат бус болох, үйлдвэр барих тухай монголчууд олон жил ярьсан нь Дорнодод газрын тос илрүүлснээс хойш бүр идэвхижсэн юм. 2015 оны 5-р сард БНЭУ-ын Ерөнхий сайд Нарендра Модиг Монголд айлчлав. Монголын эдийн засгийн хөгжилд зориулж Энэтхэг 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээл олгох болов. Энэ зээлээр газрын тос боловсруулах үйлдвэр байгуулахаар МУ-ын Засгийн газар 2017 оны 2-р сард шийдэв.






► Шатахууныг хэрэглэгчид ойртуулах, бусад нөхцөл байдлыг тооцоод үйлдвэрийг Дорноговийн Сайншандаас зүүн хойш 18 км зайд, Алтанширээ сумын нутагт барих болов. Энэ үйлдвэр жилд шингэрүүлсэн шатдаг хий 43, автобензин 340, дизель 824, онгоцны түлш 80, зуухны түлш 47 мянган тонн буюу нийт 1.35 сая тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэж МУ-ын өнөөгийн хэрэгцээг хангах юм. Түүхий тосоо Дорнод аймгийн Тосон Уул XIX, Тамсаг XXI талбайгаас татах ажээ.

ТӨСЛИЙН ЯВЦ ӨНӨӨДӨР

Энэ төслийг хариуцсан төрийн өмчит газрын тос боловсруулах үйлдвэрийн газрыг (ГТБҮ) 2017 оны 4-р сард (www.mongolrefinery.mn) байгуулав. Мөн оны 8-р сард үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулахаар Энэтхэгийн олон жилийн туршлагатай “Инженерс Индия Лимитэд” (www.engineersindia.com) компанийг зөвлөхөөр шалгаруулжээ. Дээр нь хөндлөнгийн хяналт тавиулахаар Италийн “Кинетикс Техноложи” компанийг оруулж, ажлаа эхлүүлэв. 2018 оны 11-р сард нарийвчилсан ТЭЗҮ дуусч УУХҮЯ-ны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр батлуулжээ. 2019 оны 5-р сараас инженерийн зураг төслөө боловсруулж эхлэв.

2019 оны 11-р сарын байдлаар Монголын Хөгжлийн банкны 246 тэрбум төгрөгийн зээлээр Сайншандаас 17.5 км хүнд даацын авто зам, 27 км урт төмөр зам, 110 квт-н цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцуудыг барьж үйлдвэрийн гаднах дэд бүтцийг байгуулж, үйлдвэр барих 150 га талбайг тэгшлэх, хашаа барих ажлыг эхлүүлжээ. Мөн Сайншандад 550 айлын, ажилчдын хотхон барьж байна. Ирэх хавар 42 км урт усны хоолой татах бэлтгэлийг хангаж байна. Энэ аж үйлдвэрийн томоохон цогцолборт технологийн байгууламжууд, олон том агуулах сав, түүхий тос тээвэрлэх, дамжуулах байгууламжаас гадна өөрийн цахилгаан станц багтаж байна. ►►



ТЭЭВЭР

- Одоогоор, яаралтай шийдэх гол ажил бол түүхий тосоо 550 км-ийн холоос хэрхэн тээвэрлэх асуудал. Төмөр зам барих, эсвэл дамжуулах хоолой тавих сонголтын дунд төр засгийн түвшинд санал хуваагджээ.

Төмөр замыг дэмжигсэд, энэ чиглэлээр нэгэнт МУ төмөр зам барих, Оросын нутгаар далайд шинэ гарцтай болохыг зорьж буй, тэгээд бас олон зуун сая долларын зээл авах учир олон төрлийн ачаа зөөж болохоор нь төмөр зам барих нь зөв гэх. Харин дамжуулах хоолойг дэмжигсэд болохоор хурдан, найдвартай, тасралтгүй нийлүүлэлтээ бодох нь зөв. Зардал нь төмөр зам барихаас гурав дахин хямд, барих хугацаа нь богино, дан бүтээгдэхүүн тээвэрлэх хамгийн түгээмэл, шалгарсан арга бол дамжуулах хоолой гэх.

Тамсагийн газрын тосны онцлог нь харьцангуй хөнгөн (0.845 г/см³), хүхэр маш бага (0.11 хувь), тосон дахь хүчлийн тоо бага (TAN:0.052 мг КОН/г) учир үйлдвэрийн

байгууламжийг барих материалын зардлыг хэмнэх сайн талтай. Гэхдээ парафинлаг нүүрс-устөрөгчийн нэгдлийн агуулга их, 24 хэмд царцдаг учир төмөр замаар бол халаалттай цистерн; дамжуулах хоолой бол тасралтгүй халаалттай байх ёстой.

Нэг зэрэг 80 вагон ачиж буулгах байгууламж барих их зардалтай. Халаадаг хоолой тавих туршлагатай, өөрөө санхүүжүүлээд, бариад, ажиллуулаад, хүлээлгэн өгөх сонирхолтой компаниуд бэлэн байна. Хоолой тавихад, ГТБҮ-ийн тооцоогоор 350 сая доллар шаардлагатай, хугацаа нь 2-3 жил; харин төмөр зам 660 сая доллар, барих хугацаа нь тодорхойгүй ажээ. Тээвэрлэх зардал хоолой 1 тонн нь 7 доллар; төмөр зам 2 дахин их болно гэнэ. Үйлдвэр 2024 оны 11-р сард бэлэн болж, үйлдвэрлэл 6 сарын дараа жигдэрсэн байх төлөвлөгөөтэй учир Засгийн газар энэ сонголтоо яаравчлах ёстой болжээ.

НӨӨЦ

Олон нийтийн зүгээс лавлаад буй дараагийн асуудал бол газрын тосны нөөц энэ үйлдвэрийн хэрэгцээг хангаж чадах эсэх асуулт. Зөвхөн хайгуул хийгдсэн 2 талбайд (Дорнод аймгийн Тосон Уул XIX, Тамсаг XXI) 2010 оны байдлаар нөөц 332.6 сая тонн, үүнээс баталгаатай ашиглах нөөц нь 43.2 сая тонн гэж Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэсэн. Үүнийхээ 8.2 сая тонныг олборлоод байгаа ч, нөөцөө нэмэгдүүлэх боломж их байна. Сарын өмнө л гэхэд Матад XX талбайгаас газрын тос илрүүлж, урьдчилсан байдлаар 25 сая тонн нөөцтэйг тогтоожээ. Бусад олон талбайд өрөмдсөн цооногууд газрын тосны илэрцтэй. Газрын тосны хайгуулын ажлаа өргөжүүлэх шаардлагатай ч, эрчим хүч, ажиллах хүч хангалтгүй, мөн орон нутгийн захиргаа, иргэдийн эсэргүүцэлтэй тулгарч, ажил зогсдог болжээ.

Эдүгээ газрын тосыг Хятадын компаниуд олборлож байгаа. Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлож,

борлуулсан тосны дөрөвний нэг нь манай Засгийн газарт ногддог. Мөн *газрын тосны тухай хуулийн 7.1.6-д* Засгийн газар “Монгол Улсад газрын тос боловсруулах үйлдвэр барьсан тохиолдолд гэрээлэгчид ногдох газрын тос болон өртөгт газрын тосыг тэргүүн ээлжинд, зах зээлийн үнээр худалдаж авах давуу эрхийг” эдэлнэ гэж заасан. Гэрээлэгч өөрт ногдох газрын тосыг зах зээлийн үнэ ханшаар тэргүүн ээлжинд дотоодын үйлдвэрт нийлүүлэх үүрэгтэй. Газрын тос боловсруулах үйлдвэрт түүхий эд нийлүүлэх нөөц, эрх зүйн орчин бүрдсэн гэж төрийн холбогдох албаны хүмүүс үзэж байгаа ажээ.

Ямар ч гэсэн шатахуунаар хараат бус болох харгуй зам дээрээ монголчууд бид гараад ирлээ. Эргэж буцах боломжгүй.

2019.11.28

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ | ЗОРИГЖУУЛНА | МЭДЭЛЖҮҮЛНЭ

ДАВАА ГАРАГ БҮР



НЭГ УЛИРЛЫН ҮНЭ
30.000₮

МОНГОЛ ШУУДАН
7007-8916

WWW.MONGOLPOST.MN

НИЙГМИЙН ДААТГАЛ

Нийгмийн даатгалын талаар 2009 онд бичиж
байсан нийтлэлээ эргэн сануулж байна

Амьдралын хэцүү цаг ирэхэд гэр бүл, хүүхэд, настай хүмүүсийн ганц аврал бол нийгмийн даатгал. Улс бүр эдийн засаг, хүн ам зүйн бүтэцдээ тохируулан нийгмийн даатгалын тогтолцоог хөгжүүлдэг. Өндөр настай болоод хэрэглэх тэтгэвэр, хөдөлмөрийн чадвараа алдах, ажилгүй болбол авах тэтгэмж, өвдвөл эмчлүүлэх зардлаа хийж бүтээж байхдаа хуримтлуулж, олон жилээр нийтийн санд хадгалуулан арвижуулж, цаг нь ирэхээр буцаан авч хэрэглэх Таны баталгаат хөрөнгө бол нийгмийн даатгал.

Энэ бол улс орон иргэн бүрээсээ эрүүл саруул, залуу байхад нь хүчээр хураан цуглуулж, нийтийн хэрэгцээнд ашиглаж байгаад цаг нь болохоор буцааж олгодог, нийгэмд бий болдог томоохон хөрөнгийн сан. Манай улс ч адилхан танаас энэ мөнгийг хуулийн хүчээр авдаг. Таны цалингийн 10 хувийг өөрөөс тань, бас 10 хувийг таны ажил олгогчоос хураадаг. Өөрөөр хэлбэл, таны гэртээ авчрах байсан орлогын 20 хувийг төр авч байгаа хэрэг. Ноднинг хүртэл бүр 29 хувь байсан юм. Энэ хураамжийн нэг хувийг таны тэтгэмжид, дөрвөн хувийг эрүүл мэндийн даатгалд, нэг хувийг ажилгүйдлийн даатгалд, үлдсэн 14 хувийг насны буюу тэтгэврийн даатгалд авч байгаа гэдэг. Та 40 жилийн турш сар бүр хураалгана. Цагтаа хураалгаагүй бол бас торгууль төлнө. Шоронд ч орж магадгүй. Хурааж авах талд бол ямар ч асуудал байхгүй.

Харин буцааж өгөхөд маш их асуудал байдаг. Нэгдүгээрт танаас яг хэдийг авсан, тэр хөрөнгө хаана хуримтлагдаж, яаж ашиглагдаж байгааг хэн ч мэдэхгүй. Улс төрийн нам нэрээр төрийн эрхэнд гарсан хэсэг хүмүүс Таны өмнөөс ээлж дараалан түүнийг захиран зарцуулна. Хэдэн хувиар яаж өсгөж байгаа нь нууц. 40 жилийн дараа юмны үнэ олон дахин өсөж болох ч танд өгөх үед хэн ч үүнийг тооцохгүй. Уг нь энэ мөнгө таны нэрийн дансанд, банкинд байсан бол өөр хэрэг л дээ.

Өмнө нь авсан мөнгөөр маань юу хийснээ нуудаг дарга нар, сүүлийн үед нэмж авах тухай ярих боллоо. Өмнөх буруугаа шүүлгээгүй байж дахин авах тухай дээрэмчид л ярьдаг. Соёл иргэншилтэй улс орнуудад сонгогдсон засаглалын бүхий л үйл ажиллагаа, түүний дотор нийтийн хөрөнгийг хэрхэн хуримтлуулж, юунд зарцуулж байгаа нь маш тунгалаг, тов тодорхой харагддаг. Иргэд нь насны эцэст хэрэглэх хөрөнгийг нь яаж өсгөж байгаа талаарх мэдээллийг тогтмол авч, нийгмийн даатгалын хуримтлалаа өвдөж зовбол

хэрэглэх баталгаа гэж үзэн, сэтгэл тэнүүн ажиллаж амьдардаг.

Уг нь манай улсад 1960 оноос хойш төрсөн хүн бүрт нэрийн данс нээгээд хэдэн жил болж байгаа. Харин хүмүүс дансандаа хэдэн төгрөг байгааг мэддэггүй. Тэр мөнгө ер нь байгаа эсэх нь эргэлзээтэй.

Чили улсад л гэхэд энэ мөнгийг тодорхой хүүтэй өсгөхийн тулд дотор нь хэд ангилж, хөрөнгө оруулалтын сан байгуулан улсын бонд, тодорхой компаниудын үнэт цаас худалдаж авдаг. Сингапурт бол тэтгэврийн нэрийн данснаас гадна эрүүл мэндийн хадгаламжийн нэрийн данс байгуулдаг. Бүх хүн зэрэг өвддөггүй учир эрүүл мэндийн салбараа хөгжүүлэхэд бусад хөрөнгө оруулалтын хамт хэрэглэдэг бөгөөд үр дүнд нь тэд дэлхийн түвшний эмнэлэг байгуулчихсан өөрийн болон гадаадын иргэдийг эдгээж байх жишээтэй. Тэд монголчууд шиг зөвхөн оношоо зөв тогтоолгохын төлөө бүх насаараа цуглуулсан мөнгөө шавхаад, дээр нь зээл авч гадаад явдаггүй. Сингапурт хувь хүн үндсэн хөрөнгө авахдаа тэр хадгаламжаасаа нэг удаа бас авах эрхтэй. Энэ нь хааяа нэг шинжилгээ хийлгэхээс өөр өвчин зовлонгүй хүнд бол илүү ашигтай.

Нийгмийн даатгалд хуримталсан их хөрөнгийг орон сууцны урт хугацааны зээлтэй зөв холбох гэх мэтээр нийгмийн даатгалын хөрөнгийг зөв өгөөжтэй зарцуулж чадвал хөгжлийн асар их нөөц боломж байгааг монголын төр, засаг ойлгож, мэдмээрсэн. Нийгмийн даатгал бол хөдөлмөрлөж байгаа хүн бүр хамтын санд хуримтлуулан хадгалуулж, нийгмийн хөгжлийг санхүүжүүлэхэд хэрэглүүлж байгаад бэрхшээл зовлон тохиолдсон, өтөл буурал насанд хүрсэн үедээ авч хэрэглэдэг хэрэгсэл билээ. Буцааж авах цагт энэ хөрөнгө хорогдсон биш, өссөн байх учиртай.

2009.10.21



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2019.11.24-ний дугаар
Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

ОЮУТОЛГОЙН ГЭРЭЭГ САЙЖРУУЛАХ УУ?

Өнгөрсөн Пүрэв гарагт УИХ-ын чуулганы хуралдаанаар “Оюутолгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” тогтоолын төслийг хэлэлцэж баталлаа. Ерөнхийдөө энэ төсөл нь хөрөнгө оруулалтын гэрээ болон бусад гэрээ хэлэлцээрүүдийг сайжруулж, гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах зорилготой. Мөн үүнээс өмнө Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхээс Дубайн гэрээг байгуулахтай холбоотой өмнөх Засгийн газрын 4 шийдвэрийг хүчингүй болголоо гэсэн мэдээлэл гарсан.

Оюутолгой ордын зэс алтны нөөцийн ТЭЗҮ-ийг 2010 онд баталсан. Дараа нь 2015 онд шинэчлэн баталсан. Хуулийн дагуу таван жил тутамд шинэчлэн батлах үүрэгтэй. 2015 оны ТЭЗҮ-ээр Оюутолгой орд цэвэр зэс 31.4 сая тонн, алт 1200 тонн, мөнгө 2750 тонн нөөцтэй гэж батлагдсан.

Монгол улс ба гадаадын хөрөнгө оруулагчид 31.4 сая тонн зэсийн олборлох нөөцөөрөө дэлхийд гуравт орж буй Оюутолгойн орд газрыг ашиглах гэрээг зураад яг 10 жил болж байна. Орд газрыг монголын Засгийн газар 34, АНУ, Канадын хөрөнгийн биржид бүртгэлтэй Туркойз Хилл Ресурс компани 66 хувийг нь эзэмшиж байна. Туркойз Хилл Ресурсын 51 хувь нь дэлхийн хоёр дахь том уул уурхайн компани Рио Тинтод очсоноор ОТ ордыг олборлох боломж ийнхүү бүрдсэн. ОТ-н нөөцийн 20 хувь нь ил, 80 хувь нь газрын гүнд 700-1300 метрийн дор оршдог.

ОТ бол монголын эдийн засгийг хөтлөгч хамгийн том төсөл. Төслийг хэрэгжүүлэхийн тулд олон гэрээ байгуулж, шинэчилж ирлээ. Хөрөнгө оруулалтын, хувьцаа эзэмшлийн, гүний уурхайн, нэмэгдэл, дубайн гэрээ гэх мэт. Олон алдаа, дутагдал гарсан тухай УИХ-ын ажлын хэсгийн тайланд нэлээн нухацтай гаргаж тавьсныг тэмдэглэх хэрэгтэй. Техник эдийн засгийн



үндэслэл (ТЭЗҮ)-ээ тохиролцоогүй байж хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан, үр дүнд нь төслийн зардал анх тохирсноосоо хоёр дахин өсчихсөн, хөрөнгө оруулагч нь тэр зардлынхаа 3 хувиар менежментийн төлбөр авдаг, зардлын нэр томьёоны тухай нэгдсэн ойлголт байхгүй учир татварын маргаан үргэлж гардаг зэрэг олон асуудал, сорилтууд тулгарсаар байна. 2009-2015 оны хооронд 3.2 их наяд төгрөгийн татварын зөрчил гарсан гэж тус Ажлын хэсгийн тайланд оржээ.

Гэхдээ энэ бүхнийг хоёр тал ширээний ард сууж ярилцах, ойлголцох, засч залруулах хугацаа нөхцлөө урьдчилан тохирч ажиллах, дүгнэх замаар явж л харилцан итгэлцэл бий болно. Зөвхөн харилцан итгэлцэл тогтсон цагт л хамтын ажиллагаа өндөр өгөөжтэй, харилцан ашигтай болдог.

Монголын тал эдүгээ том төслүүдэд хувьцаа эзэмшихийн оронд эхнээсээ татвар, төлбөрөө илүү аваад явах нь зөв гэж ярих боллоо. Энэ хувилбарыг одоо байгаа нөхцөлтэй харьцуулан судлах, 34 хувиа яаж үнэлэх, хэнд борлуулах, өрөндөө хэдийг нь суутгах, төслөөс авах татвар, төлбөрийн хувь хэмжээг яаж өөрчлөх зэргийг ярилцаж эхлэх хэрэгтэй

байна. Тийм учраас ОТ төслийг дахиад л сонгуулийн шоу болгож биш, сонгуулийн дараа тогтон сууж, товлон ярилцах хэрэгтэй байна. Түүнээс биш зарим түшмэдийн саналаар гэрээгээ цуцлах аваас Монгол улсын хувьд “хөл рүүгээ буудсантай” адил юм. Энэ төслийг худалдан авахад бэлэн хөршүүд ч бий. Гуравдагч хөршүүд, тэдний зээл олгосон банкууд харин монголчууд гэрээгээр тохирсон ажлаа яаж хэрэгжүүлж буйг анхааралтай ажиглаж байгаа.

Мөн нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс Дубайн гэрээг байгуулахтай

холбоотой Ч.Сайханбилэгийн Засгийн газрын дөрвөн захирамжийг хүчингүй болгох шийдвэр гаргасан. Энэ нь Монгол улсын Засгийн газар буюу хувь нийлүүлэгчийг төлөөлж “Оюу толгой” төслийн далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтийн төлөвлөгөөнд гарын үсэг зурахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан, “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Ганболд нарт зөвшөөрсөн Монгол улсын Ерөнхий сайдын 2015 оны 5-р сарын 15-ны өдрийн 123 дугаар захирамжийг хүчингүй болго гэсэн шийдвэр гараад байна.

НИЙГМИЙН ДААТГАЛ ТОЙРСОН УЛС ТӨР

Ирэх оноос нийгмийн даатгалын шимтгэлийг дахин нэмэгдүүлж ажил олгогч, ажилтан тус бүр нэг хувийг нэмж төлөхөөр болсон. Нийгмийн даатгалын тогтолцоогоо сайжруулаагүй атал сүүлийн 3 жил дараалан НДШ нэмж байгаад олон нийт дургүйцэж байгаа. Түүнчлэн “Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо”, “Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо” зэрэг холбоод эсэргүүцлээ илэрхийлсэн. Мөн Ерөнхийлөгч энэ нэмэгдлийг эсэргүүцэж хориг тавина гэдгээ хэлсэн. Харин Сангийн сайд 2017 онд ОУВС-ийн хөтөлбөрт хамрагдсанаар нийгмийн даатгалын сангийн алдагдлаа бууруулах үүрэг даалгавар авсан. Улмаар сангийн алдагдлыг бууруулахын тулд 2020 он хүртэл нийгмийн даатгалын шимтгэлийг нийт 5 хувиар нэмэгдүүлэхээр болсон гэж хэлсэн.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг “Капитал банкинд намайг сайдаар томилогдож ирэхэд Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл 280 орчим тэрбум төгрөгийг байршуулсан байсан. 2009 оноос эхлэн Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг “Капитал” банкинд байршуулж байсан байдаг. Би ХНХ-ын сайдаар томилогдсоноос хойш Капитал банкинд байршуулсан хөрөнгийг нэлээн багасгасан. Гэхдээ Нийгмийн даатгалын сангийн



үлдэгдэл 101 тэрбум төгрөг Капитал банкинд үлдсэн байсан.” гэж хэлсэн.

Нийгмийн даатгалын сан нь 1.тэтгэврийн, 2.тэтгэмжийн, 3.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний, 4.ажилгүйдлийн, 5.эрүүл мэндийн гэсэн 5 сангаас бүрддэг. Эдгээр сангаас тэтгэврийн сан алдагдалтай байсаар ирсэн. Сангийн алдагдлыг нөхөх зорилгоор 2019 онд л гэхэд 600 тэрбум төгрөгийн татаас улсын төсвөөс олгосон. Энэ сан бол үндсэндээ дампуурчихсан. Удирдсан хүмүүс нь дампуураагүй зүгээр байгаа гээд өмөөрөөд л байгаа. Аливаа нэг татварыг нэмэх нь ажилгүйдлийг дэмжиж байгаа асуудал байдаг.

МОНГОЛБАНК, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ШИНЭ УДИРДЛАГУУД

**С.Даваасүрэн****Д.Баярсайхан****Н.Баяртсайхан****Б.Лхагвасүрэн**

Монгол улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг олон улсын байгууллага ФАТФ-ийн саарал жагсаалтад орсон. Улмаар манай гол хоёр санхүүгийн институт болох Монголбанк, СЗХ-ны удирдлагуудыг албан тушаалаас нь чөлөөллөө. Тэдний оронд Монголбанкны ерөнхийлөгчөөр тус банкны дэд ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнг, СЗХ-ны даргаар одоогийн дэд дарга Д.Баярсайханыг томилохыг дэмжлээ.

Тэгэхээр асуулт нь энэ 2 хүн нөгөө 2 хүнээсээ юугаараа илүү вэ? Энэ 2 хүн гарч ирээд юу өөрчлөгдөх вэ? Зарчмын хувьд өөрчлөгдөхгүй юм бол анхнаасаа яагаад сольсон бэ?

Саарал жагсаалт бол зөвхөн энэ 2 институтийн ажил биш. Хууль хүчний байгууллага, шүүх засаглал гээд бүгдийнх нь ажил. Мөнгө угаахтай холбогдсон хэргүүдийг монголын шүүх шийдэж чадахгүй байна. Олон хэрэг мөрдөгддөг. Өндөр албан тушаалтай олон хүнийг баривчилж байсан. Хоёр ч Ерөнхий сайд асан, Сангийн сайд асан, төрийн өмчит компанийн

удирдлагууд, хамгийн том банкны эзэн гэх мэт. Монгол улсад гүйцэтгэх засаглал, шүүх, хүчний байгууллагууд хоорондоо хамтарч ажиллахгүй байна. Товчоор, шударга ёс байхгүй, хангах механизм нь ажиллахгүй байна. АТГ мөрдөж, шалгаад хэдэн зуун хэргийг шүүхэд шилжүүлэх хүсэлтээ прокурорт явуулдаг боловч, тав аравхан хувь нь шүүхэд очдог. Бусад нь яасан тухай прокурор иргэдэд тайлан тавьдаггүй. Шүүхэд очсон хэргүүд бараг бүгд л есөн шидийн шалтаг, шалтгаанаар шүүх хурал нь хойшилсоор, хөөн хэлэлцэх хугацаа гэгч нь дуусаад хаагддаг гажиг зуршил тогтчихсон. Энэ бол шүүх тогтолцоо шударга үнэнд биш, авлигачдад үйлчлэх болсныг тод харуулж байна. Монгол улсын прокурор, шүүхийн систем авлигачдын гар хөл болсноос мөнгө угаах хэрэг газар авч, улс дотроо шийдэж чадахгүй хэмжээнд хүрч олон улсын байгууллага саарал жагсаалтад оруулсан нь энэ.

Зүгээр нэг феодалийг нөгөөхөөр нь солиод, сонгуульд бэлдээд байна уу.

*Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв
Тоймын бүрэн эхийг jargaldefacto.com вебсайтаас үзэх боломжтой.*

Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com
☎ +976 94109342
🌐 www.defacto.mn
www.jargaldefacto.com